

Ж. Батсайхан

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН  
ЗАСАГ, НИЙГМИЙГ  
2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ,  
2016-2017 ОНЫ ХАНДЛАГА**

АРГА ЗҮЙН ХЯЛБАРШУУЛСАН  
ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот  
2014 он

## Өмнөх үг




Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцийг бууруулах, төсвийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хөрөнгө оруулалт, татварын бодлогоор дэмжих, ажилгүйдлийн түвшинг бууруулах, эдийн засгийг дэмжсэн санхүү, зээлийн бодлого хэрэгжүүлж, бодит салбар тус бүрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой бодлого арга хэмжээнүүдийг тусгалаа.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хоёр оронтой тоонд, инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгах, ажилгүйдлийн түвшинг 6.6 хувь хүртэл бууруулахаар төлөвлөв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг иргэдэд танилцуулах, улмаар улс орныхоо хөгжлийг төлөвлөх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд тус дэм болох энэхүү арга зүйн хялбаршуулсан танилцуулгыг Иргэн танд хүргүүлж байна.



---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА  
Б.ГАРАМГАЙБААТАР**

## **ТОВХИМОЛООС ЮУ МЭДЭЖ БОЛОХ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙД**

Товхимолтой бүхэлд нь танилцсанаар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөхөд хэрэглэгддэг гол гол үзүүлэлт, тэдгээрийн тодорхойлолтууд, тооцооны зарим аргачлал, 2015 онд улс орноо хөгжүүлэх талаар тавьж байгаа зорилтууд, хэрэгжүүлэх томоохон арга хэмжээний талаар товч ойлголт авах болно.

Товхимолын хэсэг тус бүрийн агуулгын задаргааг нарийвчлан дугаарласан (1.2.1. гэх мэт) нь сонирхсон зүйлтэйгээ хэсэгчилэн танилцах боломжийг олгоно.

Эдийн засаг, нийгмийн асуудлын гол гол үзүүлэлтүүд, тэдгээрийн нэр томъёоны тодорхойлолт, тооцооны аргачлалын талаар товч ойлголт өгөх үүднээс тусгайлан хайрцагласан “тодруулга”-ыг хийж өгөв.

**I хэсгээс** эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2016–2017 оны хандлагын талаар “зорилт–арга хэмжээ” гэсэн дарааллаар,

**II хэсгээс** УИХ–ын тогтоол, шаардлагатай зарим албан мэдээлэлтэй танилцах боломжтой.

Энэхүү товхимолд тусгагдсан тоо баримт нь УИХ–ын 2014 оны 07 дугаар сарын 01–ний 53 дугаар тогтоол, Засгийн газраас УИХ–д өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл, түүний танилцуулга, хавсралт тооцоо, тоо баримтаас эх сурвалжтай болно.

Боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн  
багийн гишүүд

## АГУУЛГА

### I ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2016–2017 ОНЫ ХАНДЛАГА 5–40

<b>1.1. 2015 оны үндсэн чиглэлийн агуулга, зорилтууд</b>	<b>6</b>
<b>1.2. Макро эдийн засгийн 2015 оны төлөв</b>	<b>8</b>
1.2.1. Эдийн засгийн бодит өсөлт	9
1.2.2. Хэрэглээний үнийн түвшин /инфляци/	12
1.2.3. Валютын ханшны төлөв	15
1.2.4. Гадаад худалдааны төлөв	17
1.2.5. Төлбөрийн тэнцлийн төлөв	19
1.2.6. Улсын төсвийн орлого, зарлагын төлөв	23
<b>1.3. Бодит салбарын хөгжил 2015 онд</b>	<b>25</b>
1.3.1. Уул уурхайн салбарын хөгжил	26
1.3.2. Эрчим хүчний хөгжил	27
1.3.3. Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил	28
1.3.4. Зам тээвэр, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил	29
<b>1.4. Хүний хөгжил 2015 онд</b>	<b>31</b>
1.4.1. Боловсрол, шинжлэх ухаан	33
1.4.2. Соёл урлаг, спорт, аялал жуулчлал	35
1.4.3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал	36
1.4.4. Эрүүл мэнд	37
<b>1.5. Бүс нутаг, байгаль орчны салбарын төлөв 2015 онд</b>	<b>38</b>
<b>1.6. Гадаад бодлого, батлан хамгаалах салбар 2015 онд</b>	<b>39</b>
<b>1.7. Засаглал, эрх зүйн шинэчлэлийн төлөв 2015 онд</b>	<b>40</b>

### II ХЭСЭГ. АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД 41–60

<b>2.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоол</b>	<b>42</b>
<b>2.2. Хавсралтууд</b>	<b>58</b>



**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН  
ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД  
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ,  
2016-2017 ОНЫ ХАНДЛАГА**

## 1.1. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АГУУЛГА, ЗОРИЛТУУД

А  
Г  
У  
Л  
Г  
А

2015

- ✓ Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд Шинэчлэлийн Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцийг бууруулах, төсвийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хөрөнгө оруулалт, татварын бодлогоор дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах, эдийн засгийг дэмжсэн санхүү, зээлийн бодлого хэрэгжүүлж, салбар тус бүрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ✓ Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хөдөө аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлал, үйлчилгээний салбаруудыг дэмжих чиглэлээр тодорхой бодлого хэрэгжүүлэн ажиллах бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн үр дүнгээр ДНБ-ий өсөлтийг ханган ажиллах бодлого баримтална.
- ✓ Нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

- Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого баримтална.
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтлахын зэрэгцээ, санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.
- Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.
- Уламжлалт мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулна.
- Тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжсэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.
- Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.
- Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.
- Хүн амын орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулж, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлнэ.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.
- Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.
- Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.
- Соёл, урлаг, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг баримтална.
- Нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.
- Хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх бодлогыг баримтална.
- Олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.
- Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаална.
- Батлан хамгаалах, хил хамгаалалт, иргэний хамгаалалтын салбарын чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.

## 1.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН 2015 ОНЫ ТӨЛӨВ

З  
О  
Р  
Л  
Т

2015

- ✓ Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого баримтална.

### Тодруулга 1

- **ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:**

Аливаа улс орны төр засгаас эдийн засгийн талаар заавал шийдвэрлэж байх дараахь зорилтуудыг эдийн засгийн бодлого гэнэ. Үүнд:

Эдийн засгийн эрх чөлөөг хангах

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй үйлдвэрлэгч, хэрэглэгч бүх субъектийн эрх мэдэл, өмчийн эрх чөлөөг хангах, сонголт хийх боломж олгох

Ажлаар бүрэн хангах

Ажлын чадвартай ажиллахыг хүсч буй бүх хүмүүс ажилтай байх бололцоог хангах замаар ажилгүйдлийн түвшинг зохистой хэмжээнд барих

Эдийн засгийн өсөлтийг хангах

Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх

Үнийн тогтвортой байдлыг хангах

Инфляцийн эсрэг үйл ажиллагаа явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах

Орлогыг шударга хуваарилах

Цөөн бүлгийн тансаг хэрэглээг улам нэмэгдүүлж, нөгөө бүлгүүдийн амьдралыг ядууралд оруулахгүй байхуйцаар орлогыг хуваарилах

Хүн амд эдийн засгийн халамж үзүүлэх

Хөдөлмөрийн чадваргүй, ажил хийх боломжгүй хүмүүсийн амьдралын баталгааг хангах

Гадаад худалдааны тэнцлийг хангах

Гадаад худалдаа, санхүүгийн гадаад харилцаанд оновчтой тэнцвэр бүрдүүлэх

Хүрээлэн буй орчныг хамгаалах

Эдийн засгийн хөгжил ба хүрээлэн буй орчны зохицолдоог хангах




## 1.2.1 ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

2015



- Эдийн засгийн бодит өсөлтийг 10 хувиас доошгүй байлгана.
- Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний\* хэмжээг 5000.0 ам.доллараас дээш түвшинд хүргэнэ.

**Эдийн засгийн өсөлт, 2015 он.**



**Эдийн засгийн өсөлт, салбараар**

	2012	2013	2014*	2015**
ДНБ-ий бодит өсөлт	<b>12.4</b>	<b>11.7</b>	<b>11.2</b>	<b>10.2</b>
Хөдөө аж ахуй	21.6	13.5	8.7	9.6
Үйлдвэр	9.1	9.9	20.1	18.5
Үйлчилгээ	16.8	16.3	10.0	10.1

\* –урьдчилсан гүйцэтгэл

\* \* –төсөөлөл

тодруулга2–ыг үз

**2015 онд  
Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх  
хүчин зүйлүүд**

- ✓ Худалдааны гол түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, экспортын бүтээгдэхүүнээ тогтвортой нийлүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай байна. Үүний үр дүнд ирэх жилүүдэд нүүрсний экспорт тогтвортой нэмэгдэнэ гэж төсөөлж байна. Түүнчлэн, ДЦС-3 болон ДЦС-4-ийн өргөтгөл, шинээр баригдаж байгаа бөгөөд бусад дулааны болон цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээ нэмэгдэх юм.
- ✓ УИХ-аас алтны олборлолтыг нэмэгдүүлэн, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор тус бүтээгдэхүүнд ногдох нөөц ашигласны төлбөрийг бууруулсан. Ингэснээр алтны олборлолт ирэх жилүүдэд эрчимтэй нэмэгдэх боломжтой юм.
- ✓ Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессоор авто замын томоохон төслүүд, үүнд Алтанбулаг-Замын Үүдийн чиглэлийн хурдны замын төсөл, Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн авто замын төсөл, мөн орон нутгийн шинж чанартай авто замуудыг барихаар төлөвлөсөн.
- ✓ ДЦС-5 болон нүүрсний уурхайг түшиглэн цахилгаан станцуудыг барих бэлтгэл ажлыг хангаж байгаа бол Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замыг 2015 онд багтаан ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Нөгөө талаар иргэдийг орон сууцжуулах, гэр хорооллын дахин төлөвлөлт, хувийн орон сууцны хороолол байгуулах зэрэг ажлыг үргэлжлүүлэн эрчимтэй өрнүүлнэ. Ингэснээр барилга, угсралтын салбар 2015-2017 онд жилд дунджаар 8 орчим хувиар өсөхөөр төсөөллөө.
- ✓ Боловсруулах аж үйлдвэрийн салбарыг дэмжих хүрээнд 2014 онд Чингис бонд болон бусад эх үүсвэрээр экспортод чиглэсэн, импортыг орлох үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулж байна. Эдгээр төслүүдэд барилгын материал, нэхмэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг багтаж байгаа юм. Үйлдвэржилтийг дэмжих бодлогын хүрээнд үйлдвэржилтэд шаардлагатай санхүүгийн тогтолцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч, экспортын болон зээлийн эрсдлийг даатгах даатгалын компани байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр боловсруулах аж үйлдвэрийн салбар жилд 10 орчим хувиар өсөхөөр төсөөлж байна. Тус салбарыг болон эдийн засгийн өсөлтийг дэмжсэн санхүүгийн тогтолцоог бүрдүүлж чадсанаар эдгээр салбарууд хөгжихөөс гадна санхүүгийн зах зээл, санхүүгийн салбарын үйлчилгээ хөгжих боломжтой.
- ✓ Шинэ төмөр замын эхний хэсэг болох Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр зам 2015 онд ашиглалтад орж, төмөр замын тээвэрлэлт ирэх жилүүдэд хурдтай нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Аж үйлдвэр, барилга, тээвэр гэсэн эдийн засгийн голлох салбаруудын өсөлтийн үр дүнд худалдааны салбар болон бусад үйлчилгээний салбаруудын гарц нэмэгдэж хөгжилд ихээхэн дэмжлэг үзүүлэх юм.

## Эдийн засгийн бодит өсөлт, 2013–2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр



- 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засаг 11.7 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ нэрлэсэн үнээр 17,550.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 2013 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3972.4 ам.доллар болов.
- Эдийн засгийн бодит өсөлтийг 2014 онд 11.2 хувь байхаар урьдчилан төсөөлж байна.
- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2014 онд 4254.5 ам.долларт хүрэх урьдчилсан тооцоо гарч байна.

### Тодруулга 2



- **ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ** гэдэг нь дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж, Улсын Их Хурлаас зөвшөөрсөн баримт бичиг юм.
- **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ.** Эдийн засгийн өсөлтийг нэлээд өргөн хэрэглэгдэж байгаа дараах хоёр тодорхойлолтоор хэмждэг:
  - ✓ Ашиглаж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тоо хэмжээг нэмэгдүүлсний буюу техник технологийг боловсронгуй болгосны үр дүнд үндэсний хийт бүтээгдэхүүн /ҮНБ/-ий хэмжээнд гарах бодит өөрчлөлтөөр
  - ✓ Нэг хүн амд ногдох бодит орлогын хэмжээ нэмэгдэх буюу ҮНБ-ний бодит хэмжээ өсөх үйл явцаар

$$\text{Эдийн засгийн өсөлтийн хурдац} = \frac{(\text{тухайн оны ҮНБ}) * 100\%}{\text{суурь оны ҮНБ}}$$

- Улс орны дотооддоо тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг **“ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН”** гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүчний нөөцөөр нэг жилд үйлдвэрлэж бий болгосон материал баялгийн хэмжээг зах зээлийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна. Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.
- ДНБ дээр тухайн улсын иргэдийн гадаад дахь хөрөнгө оруулалтаас олох орлогыг нэмбэл үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ гарна.
- Улс орны дотооддоо тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг **“ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН”** гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүчний нөөцөөр нэг жилд үйлдвэрлэж бий болгосон материал баялгийн хэмжээг зах зээлийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна.

## Тодруулга 2-ийн үргэлжлэл



Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.

- ДНБ дээр тухайн улсын иргэдийн гадаад дахь хөрөнгө оруулалтаас олох орлогыг нэмбэл үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс капиталын элэгдэлийн шимтгэлийг хасвал **ҮНДЭСНИЙ ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.
- Дотоодын нийт бүтээгдэхүүнээс шимтгэлийг хасвал **ДОТООДЫН ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс шимтгэл ба шууд биш татваруудыг хасвал цэвэр орлогуудын нийлбэр буюу **ҮНДЭСНИЙ ОРЛОГО** гарна.
- Үндэсний орлогоос пүүсүүдийн хувьцаа эзэмшигчиддээ өгөлгүй хөрөнгө оруулалт хийсэн ашиг болон татварыг хасч дээр нь тэтгэвэр, тэтгэмж зэрэг эдийн засагчдын хэллэгээр “шилжүүлэх төлбөр”-ийг нэмбэл хүмүүсийн гар дээр бэлэн очих “хэрэглээнд зарцуулах” буюу **“БЭЛЭН ОРЛОГО”** гарна.


### 1.2.2. Хэрэглээний үнийн түвшин (Инфляци)

2015



- Бодит эдийн засаг, мөнгө, сангийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, инфляцийн зорилтот түвшинг /жилийн дундаж хэмжээ/ нэг оронтой тоонд байлгана.

### Инфляцийн түвшин



\*тодруулга 3-ыг үз

**2015 онд  
Инфляцид нөлөөлөх хүчин зүйлс:**

- ✓ Хэрэглээний гол бүтээгдэхүүн болох мах, гурил, барилгын материал, мөн суурь бүтээгдэхүүн шатахуун, эрчим хүчний үнийг төрөөс шууд бус аргаар зохицуулахаар төлөвлөж байна. Засгийн газрын 2013 оны 352-р тогтоолоор Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 80.5 мянган тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэхээр баталсан нь шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалж, улмаар шатахууны жижиглэнгийн үнэ тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн юм.
- ✓ “Чингис Бонд”-ын хөрөнгөнөөс дэд бүтэц, үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтыг дэмжихээр төлөвлөөд байна. Тухайлбал, импортын бараа, бүтээгдэхүүнийг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төсөл, барилгын материалыг дотоодод үйлдвэрлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна

**Хэрэглээний үнийн индекс /инфляци/,   
2013–2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр**

- Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин 2013 оны эцсээр улсын хэмжээнд 12.5 хувьтай гарлаа.
- 2014 онд нийлүүлэлтийн шинж чанартай инфляцийн түвшин буурах хандлагатай байгаа бөгөөд мөн гол түнш орнуудын инфляцийн түвшин бага байхаар хүлээгдэж байгаа зэргээс үүдэн манай улсын инфляцийн түвшинг 2014 онд нэг оронтой тоонд байлгах зорилтыг тавьж байна.



### Тодруулга 3

- **ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН** (Инфляци). – Энэ нь үнийн индексийн тусламжтай хэмжиж байгаа өргөн хэрэглээний бүлэг барааны буюу хэрэглээний сагс болгон тооцсон барааны үнийн дундаж түвшинг тодорхойлдог. Үнийн индекс нь тодорхой хугацааны доторх үнийн дундаж түвшингийн өөрчлөлтийг илэрхийлэх ба дараах томъёогоор тооцно.

$$\text{Тухайн жилийн үнийн индекс} = \frac{\text{Тухайн оны үнэ} * 100\%}{\text{Суурь оны үнэ}}$$

- ✓ Хэрэглээний сагс гэдэг бол амьдралынхаа хэвийн үйл ажиллагааг хангаж байгаа статистикийн дундаж амьжиргаатай гэр бүлийн хэрэгцээг хангахад зайлшгүй шаардагдах бараа үйлчилгээний цуглуулга юм.
- ✓ Манай оронд хэрэглээний үнийн индексийн сагсыг 1991 оны 9–р сараас Олон улсын Валютын сангийн аргачлалаар тооцож эхэлсэн бөгөөд 2001 оноос эхлэн хэрэглээний сагсанд 280 гаруй нэрийн бараа, үйлчилгээг багтааж хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

### 1.2.3. Валютын ханшны төлөв

2015



- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэх, уян хатан тогтох зарчмын үргэлжлүүлэн баримтална.

#### Тодруулга 4



#### Валютын ханшийг тодорхойлдог хүчин зүйлүүд:

- ✓ Эдийн засгийн гол үйл явдлууд / арга хэмжээнүүд/
- ✓ Бүтээмжийн өөрчлөлт
- ✓ Мөнгө санхүүгийн талаарх төрийн бодлого
- ✓ Үнэ, зээлийн хүү
- ✓ Улс төр, сэтгэл зүйн хүчин зүйлүүд
- ✓ Хүлээлт
- ✓ Гадаад валютын эрэлт нийлүүлэлт

- **Валютын зах зээлийг зохицуулах талаар Засгийн газраас авч байгаа арга хэмжээ нь өөрийн үндэсний валютын ханшид девальвац болон ревальвац хийх чиглэлээр валютын зах зээлийг өдөөж байдаг.**

- ✓ **Девальвац нь** өөрийн орны валютын солилцооны ханшийг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг. Девальвацийн үед бусад орнууд худалдан авсан бараандаа бага валют төлөх учраас тухайн орны бараа үйлчилгээний үнэ олон улсын зах зээл дээр хямдрана. Хилийн чанадаас худалдан авсан бараа үйлчилгээний үнэ нэмэгдэж, улмаар импорт хумигдахад нөлөөлж, дотоодын эрэлт буудаг.

- ✓ **Ревальвац нь** өөрийн орны валютын солилцооны ханшийг өсгөхөд чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг.

- ✓ **Валютын интервенц нь** гадаад орны валютыг худалдах, худалдан авах замаар үндэсний валютын ханшид нөлөөлөх үйлдэл.

## Тодруулга 5



- **Голланд өвчин:**

Эдийн засагт шинээр хөрөнгө оруулалт орж ирэх нь бусад салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн зарим салбарт уналтад орох тохиолдол байдаг. 1959 онд Нидерландын хойд тэнгист газрын тос илэрсний улмаас газрын тосны үйлдвэрлэл нэмэгдэж улмаар тосны экспорт өсчээ. Гэвч дотоод валютын ханш чангарсны улмаас бусад салбарын экспорт буурч, гарын тосноос буса салбарт ажилгүйдэл нэмэгдэх байдлаар эдийн засагт сөргөөр нөлөөлсөн байна. Ханшийн чангаралтын нөлөөгөөр боловсруулах салбарын худалдаалагддаг төрлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар буурч, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг энэхүү байдлыг голланд өвчин гэж нэрлэдэг бөгөөд газрын тосны олборлолтоос өмнө Нидерландын экспортын гол бүтээгдэхүүн байсан Алтанзул цэцгийн экспорт эрс буурч, эдийн засгийн өрөөсгөл бүтэц бий болж байжээ. Тодруулбал, эдийн засгийн нэг салбарын үйл ажиллагаа бусад салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхийг ГОЛЛАНД ӨВЧИН гэдэг байна.

- **Баялгийн хараал:**

Ангола, Нигер, Судан, Конго зэрэг Африк тивийн ихэнх орнууд газрын тос, очир алмаз гэх мэт үнэтэрдэнээр баялаг боловч байгалийн баялаггүй зүүн өмнөд Азийн орнууд болох Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур зэрэг оронтой харьцуулахад амьдралын чанар доогуур, нэг хүнд ногдох орлого маш бага байна. Баялагтай боловч хөгжил буурай байгаа эдгээр орнуудыг “баялгийн хараал” тусчээ гэж дүгнэдэг. Байгалийн баялаг арвинтай орнуудын нэг хүнд ногдох орлогын өсөлт нь баялгийг ашиглаагүй үеийн нэг хүнд ногдох орлогын өсөлтөөс доогуур байх үзэгдлийг БАЯЛГИЙН ХАРААЛ гэж тодорхойлох бөгөөд улс орнууд баялгийн хараалд өртдөг олон шалтгаан байдаг байна. Тухайлбал, тухайн орны эдийн засаг цөөн тооны түүхий эд, баялгийг дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай, эмзэг бүтэцтэй байх, Засгийн газар нөөцийг үр ашиггүй удирдах, улс төрийн тогтворгүй байдал, авлигал зэрэг нь улс орныг баялгийг хараал тусахад хүргэдэг байна.



## 1.2.4. Гадаад худалдааны төлөв

2  
0  
1  
5



- ✓ Гадаад худалдааны бараа эргэлт 2015 онд 13.6 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 6.9 тэрбум ам.доллар, импорт 6.7 тэрбум ам.доллар болж болохоор байна.
- ✓ Экспортын хэмжээ 2015 онд 2014 оноос 22.7 хувиар нэмэгдэхээр байна.
- ✓ Импортын хэмжээ 2015 онд өмнөх оноос 8.0 хувиар өсөхөөр байна.

### Гадаад худалдаа, 2013–2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр



- Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 2013 онд 10.6 тэрбум ам.доллар болж 2012 оныхоос 4.5 хувиар буурав.
- Монгол Улсын нийт экспорт 2013 онд 2012 оноос 2.6 хувиар буурч, 4.3 тэрбум ам.доллар болов.
- Импорт 2013 онд 5.7 хувиар буурч, 6.4 тэрбум ам.доллар болов.
- Экспорт 2014 онд 2013 оноос 31.3 хувиар өсч, 5.6 тэрбум ам.доллар, импорт 1.5 хувиар буурч, 6.3 тэрбум ам.доллар болох төлөвтэй байна.



## Тодруулга 6

- Ямар ч улс орны хувьд гадаад худалдааны гол асуудал нь экспорт нь импортоосоо ямагт түрүүлж байх явдал юм. Энэхүү үйл явцыг улсын хэмжээнд харуулдаг нэгдсэн үзүүлэлт бол гадаад худалдааны **бараа эргэлт** юм.
- Гадаад худалдааны бараа эргэлт гэж экспорт дээр импортыг нэмсэн нийлбэрийг хэлдэг.

### **Гадаад худалдааны эргэлт = экспорт+импорт**

- Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны эргэлтийг тодорхойлдог бол экспорт, импортын зөрүүгээр гадаад худалдааны тэнцлийг тодорхойлдог.
- Хэрэв +(нэмэх) тэмдэгтэй гарвал гадаад худалдааны тэнцэл ашигтай, улс орны хөгжил дэвшил дээгүүр байгааг илэрхийлнэ.

Улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хангах үүднээс улс орон бүхэн импортоосоо давсан экспорттой байх нь хамгийн гол зорилт байдаг хэдий ч эдийн засгийн чадавхи, улс орны хөгжлийн түвшингөөс хамаараад улс орон бүхэн ингэж чаддаггүй.

Гадаад худалдааны алдагдалыг арилгах арга зам нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үүний дотор олон улсын зах зээлийн шаардлага хангасан чанартай, хүний орчин үеийн хэрэглээнд илүү нийцэж тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах явдал юм.

## 1.2.5. Төлбөрийн тэнцлийн төлөв

З  
О  
Р  
Л  
Т

2015

- Гадаад худалдаа 2015 онд ашигтай байхтай уялдан төлбөрийн тэнцлийг 510 гаруй сая ам.долларын ашигтай байхаар төсөөлж байна.

### ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ЗЕРЭГ БАЙХАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

2015

- ✓ Дунд хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон бүтээн байгуулалт, үйлдвэржилтийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсэнээр манай улсад орох гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдэхээр хүлээгдэж байна.
- ✓ Мөн Засгийн газраас экспортыг дэмжиж, импортыг орлох бодлого баримталж байгаа бөгөөд ингэснээр экспорт өсөхөөр байна.
- ✓ 2013 онд манай улсын Засгийн газраас гадаад зах зээлд шинээр 290 сая ам.долларын Самурай бонд босгож уг бондын санхүүжилт 2014 оны 1 сард орж ирэв.
- ✓ Гадаад валютын цэвэр албан нөөцийн хувьд алт олборлолтыг ил тод байлгахаар эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс “Ашигт малтмалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монголбанкинд тушаах алтны хэмжээ нэмэгдэж, гадаад валютын албан нөөцийн хэмжээ цаашид нэмэгдэх хандлагатай байна.



### Төлбөрийн тэнцэл, 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр

2013 оны гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 1883.3 сая ам.долларын алдагдалтай гарч гадаад валютын албан нөөц уг дүнгээр өөрчлөгдлөө. Өмнөх оны мөн үед төлбөрийн тэнцэл 1705 сая ам.долларын ашигтай гарч байсан.

Төлбөрийн тэнцэл /сая.ам доллар/

	2012	2013	Жилийн өөрчлөлт, %
Төлбөрийн тэнцэл	1705	-1883.3	-210
Урсгал данс	-3362.2	-3155.6	-6.1
Хөрөнгө ба санхүүгийн данс	4929.5	1471.6	-70.1

Эх үүсвэр: Монголбанкны гадаад секторын статистик мэдээлэл

Төлбөрийн тэнцлийг дансуудаар авч үзвэл, урсгал данс 3155.6 сая ам.долларын алдагдалтай гарч 2012 оны мөн үеэс алдагдал нь 6.1%-иар буурсан, хөрөнгө ба санхүүгийн данс 1471.6 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 70.1%-иар буурсан байна.

Нийт экспортын бууралт, үүнд ялангуяа нүүрсний экспорт өмнөх оноос 41 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ** бол улс орны гадаад эдийн засгийн тухайн үеийн байдлыг илэрхийлдэг чухал ойлголт юм.

Төлбөрийн тэнцэл нь тухайн жилийн хугацаанд аль нэг орны хувь хүмүүс, пүүс компани, Засгийн газрын байгууллагуудаас бусад орнуудын мөн тийм хэмжэний субъектүүдтэй хийсэн гэрээ, хэлцлүүдийн нэгтгэсэн тэнцэл бөгөөд дараахь 3 хэсгээс бүрддэг.

### **I. Урсгал дансны тооцоо (а+б+1.5.+1.6.)**

- 1.1. Барааны экспорт
- 1.2. Барааны импорт

а. Гадаад худалдааны тэнцлийн үлдэгдэл(+,-)  
ашигтай эсвэл алдагдалтай

- 1.3. Үйлчилгээний орлого
- 1.4. Үйлчилгээний зарлага

б. Худалдаа үйлчилгээний тэнцлийн үлдэгдэл (+,-)

- 1.5. Хөрөнгө оруулалтаас орох цэвэр орлого (-)
  - гадагш шилжүүлсэн ногдол ашиг
  - хамтарсан үйлдвэрийн хийсэн дахин хөрөнгө оруулалтын хэмжээ
- 1.6. Урсгал шилжүүлгүүд /цэвэр/ [+,-]
  - Засгийн газрын шилжүүлгүүд
  - Хувийн гуйвуулгууд

### **II. Капиталын хөдөлгөөн буюу Санхүүгийн ба хөрөнгийн дансны тооцоо**

- 2.1. Капиталын экспорт
  - 2.1.1. Урт ба дунд хугацааны хөрөнгө оруулалт
    - шууд хөрөнгө оруулалт
    - санхүүгийн хөрөнгө оруулалт
    - ашигласан зээл
- 2.2. Капиталын импорт
  - 2.2.1. Зээлийн үндсэн өрийн төлбөр
  - 2.2.2. Богино хугацааны зээл
  - 2.2.3. Бусад төлбөр

Санхүүгийн ба хөрөнгийн тэнцлийн үлдэгдэл (+,-)

**Нийт төлбөрийн тэнцэл = Урсгал дансны тэнцэл (I) + санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл (II)**

### **III Гадаад валютын албан нөөц**

Төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдлыг улс өөрийн төв банкны мэдэлд байгаа гадаад валютын албан нөөцийг ашиглах замаар даван туулж болдог.

## Тодруулга 7-ийн үргэлжлэл

- **Гадаад валютын цэвэр албан нөөцийг** гадаад актив / валютын харилцах, хадгаламж, кассын үлдэгдэл, мөнгөжсөн алт, гадаад орны Засгийн газрын үнэт цаас/, богино хугацаатай пассив / богино хугацаатай гадаад өр, гадаадын хөрөнгө/ –ын зөрүүгээр тооцдог.

+	<b>Гадаад актив</b> (валютын харилцах+хадгаламж+кассын үлдэгдэл+мөнгөжүүлсэн алт+гадаадын Засгийн газрын үнэт цаас)
-	<b>Богино хугацаатай пассив</b> (гадаад өр+гадны хөрөнгө)
=	<b>Гадаад валютын цэвэр албан нөөц</b>

- ✓ Мөнгөжсөн алт нь олборлосон алтыг хайлуулан цэвэршүүлж гадагш худалдахад бэлэн болгосныг хэлдэг бөгөөд гадаад валют гэж тооцогддог.

- **Гадаад валютын улсын цэвэр нөөцийг** арилжааны бүх банкуудын гадаад актив, богино хугацаатай гадаад пассивын зөрүүгээр тооцдог.
- **Нийт мөнгө /M2/ нь** банкнаас гадуур байгаа бэлэн мөнгө, банкинд байгаа харилцах дансдын үлдэгдэл /M1/ дээр төгрөгийн хадгаламж, гадаад валютын харилцах, хадгаламжийг нэмсэн нийлбэр юм.

## 1.2.6. Улсын төсвийн төлөв байдал

5 1 0 2

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын эзлэх хэмжээг 29,4 хувь,

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн нийт зарлагын эзлэх хэмжээг 31,4 хувь,

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн алдагдалын эзлэх хэмжээг 2,0 хувь

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 10,2 хувь

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ Төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, төсвийн зохистой харьцааг хадгалах.
- ✓ Гадаад улс орнуудтай байгуулсан давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох.
- ✓ Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох.

## Тодруулга 8



- **УРСГАЛ ТЭНЦЭЛ** нь төсвийн урсгал орлого, урсгал зарлагын зөрүүгээр илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн урсгал хэрэгцээгээ /зардлаа/ хасаад цаана нь өр зээл болон хуримтлал /хөрөнгө оруулалт/-д зориулагдан үлдэж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны төсвийн дотоод эх үүсвэрийн чадавхийг илтгэдэг.
- **ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ** нь төсвийн нийт орлого, нийт зарлагын зөрүүгээр тус тус илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн нийт хэрэглээг /нийт зардлыг/ хангахад дутагдаж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны Засгийн газарт нэмэлт дотоод, гадаад эх үүсвэр /зээл/ шаардагдаж байгааг илтгэн үзүүлдэг.

*Улсын төсвийн нийт тэнцэл зохих түвшинд алдагдалтай байх тохиолдолд энэ алдагдалыг:*

*–гадаад /цэвэр/*

*–дотоод /цэвэр/ эх үүсвэрүүдээр санхүүжүүлэн тэнцвэржүүлдэг.*

- ✓ *Гадаад /цэвэр/ эх үүсвэр нь төслийн болон санхүүгийн эх үүсвэр байдаг.*
- ✓ *Дотоодын /цэвэр/ эх үүсвэр нь өмч хувьчлалын орлого, банкны болон банкны бус байгууллагаас авах зээл байдаг.*
- ✓ *Цэвэр гэдэг утга нь авах өгөх хоёрын зөрүү буюу авахаас нь өгөхийг хасаад гарсан цэвэр үлдэгдэлийг хэлнэ.*



### 1.3. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ 2015 ОНД

- **Хүнд аж үйлдвэрийн** цаашдын хөгжилд Дархан–Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудад түшиглэн байгуулах “Уул уурхай–хар төмөрлөгийн цогцолбор”, Өмнийн говийн бүсийн Тавантолгой, Оюутолгой, Цагаансуварга болон бусад ордын түүхий эдийг гүн боловсруулах зорилгоор байгуулах “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор” томоохон түлхэц үзүүлнэ. Ашигт малтмалыг түүхий хэлбэрээр экспортлох явдлыг үе шаттайгаар бууруулах, нэмүү өртөг шингэсэн, хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, хүнд аж үйлдвэрийн салбараа нэгдсэн бодлого төлөвлөлттэйгээр, цогцолбор байдлаар хөгжүүлэхэд ажиллана.
- **Эрчим хүч.** Дунд хугацаанд өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын эрчим хүчний эх үүсвэрээс хангах замаар импортын хараат байдлыг бууруулах, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ая тухтай ажиллаж амьдрах орчинг бий болгох, цаашлаад томоохон чадлын эх үүсвэрүүдийг барьж байгуулах замаар эрчим хүч экспортлох боломжийг бий болгох, эрчим хүчний хэмнэлтийн тогтолцоог бий болгохоор төлөвлөөд байна.
- **Хөнгөн аж үйлдвэр.** Монгол Улсын хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн ойрын ирээдүйн зорилт нь хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн гаралтай, байнга нөхөн сэргээгддэг түүхий эд, бүтээгдэхүүнийг дотооддоо гүйцэд боловсруулж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай “Монгол брэнд” бүтээгдэхүүнийг бий болгож, түүхий эдийг дотоодын үйлдвэрт боловсруулах бодлого баримтална.

### 1.3.1. Уул уурхайн салбарын хөгжил

**ЗОРИЛТ**

**2015**

- **Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2015**

- ✓ Дархан–Сэлэнгийн бүсэд металлургийн цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх.
- ✓ Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- ✓ Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийж гүйцэтгэх.
- ✓ Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх.
- ✓ Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх

### 1.3.2. Эрчим хүчний хөгжил

**ЗОРИЛТ  
2015**

- Эдийн засгийн өсөлтийг дэмжих эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2015**

- ✓ Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр бүс нутаг дахь эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах арга хэмжээ авна.
- ✓ Цахилгаан дамжуулах сүлжээний 220 кв, түүнээс дээш өндөр хүчдэлийн шугамыг байгуулна.

### 1.3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжил

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ “Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчилж, салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх.
- ✓ Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50.0 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх.
- ✓ Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах.
- ✓ Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг дотооддоо боловсруулах.
- ✓ Монгол Улс хүн амын хүнсний гол хэрэглээ болсон мах, сүүгээр хүн амаа бүрэн хангах боломжтой хэдий ч, бэлчээрийн мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх улирлын хамаарал, анхан шатны боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх нэгдсэн стандарт, орчин нөхцөл бүрдээгүй, цаашлаад түүхий эд бэлтгэл, тээвэр логистикийн үндэсний хэмжээний нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас “Сум” төслийг санаачлан хэрэгжүүлж, сумдыг бүсчлэн хөдөө аж ахуйн, тэр дундаа мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, анхан шатны тордолт хийх, хадгалж тээвэрлэх, биржийн сүлжээгээр дамжуулан борлуулах, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллана.
- ✓ Төрөөс хөнгөн үйлдвэрлэл эрхлэх явдлыг бүхий л талаар дэмжсэн эрх зүйн болоод бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, бодлогоор дэмжих, салбарын хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тогтолцоог сайжруулах, үндэсний болон бүс, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжиж үйлдвэрлэлийн цогцолбор байдлаар хөгжүүлэх, экспортод чиглэсэн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарна.

### **1.3.4. Зам тээвэр, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил**

#### **ЗОРИЛТ 2015**

- Тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжсэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.
- Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.
- Хүн амын орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулж, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлнэ.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ 2015 онд 9 аймгийн төвийг хатуу хучилттай авто замаар холбоно. Мөн транзит тээврийг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг–Улаанбаатар–Замын Үүд чиглэлийн хурдны замыг барьж байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- ✓ “Шинэ төмөр зам” төслийн хүрээнд Ухаахудаг–Гашуунсүхайтын чиглэлийн 225 км төмөр зам шинээр баригдаж ашиглалтад орсноор төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээ 20–30 сая тонноор нэмэгдэх ба Ухаахудаг–Сайншанд–Баруун–Урт–Хөөт–Чойбалсан, Хөөт–Бичигтийн чиглэлд шинээр барих төмөр замын барилгын ажил эхэлнэ. Мандал – Зуунмод – Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах барилгын ажлыг эхлүүлэх, бүтээн байгуулалтыг ажлыг Хөгжлийн банкны санхүүжилт, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- ✓ 2015 онд Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг бүрдүүлж, шинээр Сингапур, БНЭУ руу хуваарьт нислэг гүйцэтгэх ажлыг төлөвлөөд байна.
- ✓ Алтанбулаг–УБ–Замын–Үүдийн хурдны замын ажлыг эхлүүлнэ.
- ✓ Бичигт–Баруун–Урт чиглэлийн автозамыг ашиглалтад өгнө.
- ✓ Замын–Үүдэд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулна.
- ✓ Засгийн газар, Монголбанктай хамтран хэрэгжүүлж буй үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.
- ✓ “Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр”-ийн хүрээнд сумын төвүүдэд ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- ✓ Нийт 17 аймгийн 101 байршлыг хамарсан 48506,1 га талбайд иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг хийж дуусгана.

## 1.4. ХҮНИЙ ХӨГЖИЛ 2015 ОНД

- Монгол Улсын хүн ам 2013 оны жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 2931.3 мянга болж, өмнөх 2012 оноос 2.2 хувиар өссөн байна.
- Монгол улсын хүн ам 2014–2016 онд жилд дунджаар 2.1–2.2 хувиар өсөхөөр байна.
- Монгол улсын хүний хөгжлийн индекс 1995 оноос хойш тогтвортой өсч ирсэн. 2013 оны байдлаар Монгол Улсын хүний хөгжлийн ерөнхий индекс 0.728 байна. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс нь хүний хөгжил дунд түвшний бүлэг орнуудын дунджаас дээгүүр байна. Хөгжиж буй бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин харьцангуй өндөр байна. Хүн амын боловсролын түвшний индекс 0.940 байна. Харин Монгол хүний дундаж наслалт 68.7 жил байгаа нь дэлхийн дунджаас (69.3 жил) доогуур байна.
- Дунд хугацаанд хүн амын чанарын асуудалд онцгой анхааран, нийгмийн халамж, хамгаалалд хөрөнгө дайчлахаас илүү ажиллах хүчний өнөөгийн болон ирээдүйн хандлагыг ухаалгаар хүлээн авч, тэднийг зохистой шингээх үр дүнтэй, бүтээмж өндөртэй ажил эрхлэлтийг дэмжихэд чиглэнэ.
- Хүн амын хэт төвлөрлийг багасгах, орон нутагт амьдрах таатай орчныг бүрдүүлснээр хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг сааруулж, хот, хөдөөд хүн амын тархалтыг тэнцвэржүүлэх бодлого баримтлан, нөгөө талаар хөдөөд амьдрах тав тухтай таатай орчныг бий болгохын тулд байгаль орчин ба хүн ам, эдийн засгийн нягтралыг бий болгох, үйлдвэрлэл, хүн амын хэрэглээнээс байгаль орчинд үзүүлэх дарамтыг бууруулж, байгаль орчинд ээлтэй технологи, бараа, үйлчилгээний зах зээлийн өсөлтийг дэмжих, энэ чиглэлд үр ашигтай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарна.



### Хүний хөгжлийн индекс /ХХИ/

Хүний хөгжлийн индексийг иргэдийнх нь дундаж наслалт, боловсрол (насанд хүрсэн хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал, бүх нийтийн боловсролд хамрагдсан байдал), бодит орлого (нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ, худалдан авах чадвараар хэмжигдэх амьдралын түвшин) гэсэн үндсэн гурван хэмжүүрийг ашиглан тооцож байна. Эдгээр хэмжүүрүүд нь тус бүртээ өөрийн индекстэй бөгөөд тухайн улсын дундаж наслалт нь 85, нэг хүнд ногдох ДНБ жилд 40 мянган ам.доллар, насанд хүрсэн бүх хүн уншиж, бичиж чаддаг, хүүхэд багачууд нь бүх шатны сургуульд 100 хувь хамрагддаг бол "1" гэсэн оноо авах юм. Хүний хөгжлийн индексийг гаргаснаар хувь хүний амьдралын түвшинг дээшлүүлж, нийгмийн бүх салбарт хөгжиж, боловсрох боломжийг бий болгох арга хэмжээ авахад ашигладаг байна.

- ✓ **Боловсролын индексийг** насанд хүргэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал, бага дунд дээд боловсролд хамрагдсанаар тэгээс нэг хүртэлх оноогоор хэмжиж байгаа бөгөөд 0.9-өөс дээш оноо авах нь боловсролтой, хөгжилтэй улсыг илэрхийлдэг байна. Хүн амын боловсролын түвшний индексээр хамгийн өндөр нь Австрали Улс (0.993), Норвеги Улс (0.989) тэргүүлж байна.
- ✓ **Дундаж наслалт** өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн хувьд хүчирхэг бөгөөд иргэд нь өрсөлдөх чадвар хамгийн өндөр байдагийг үздэг байна. Дэлхийд дундаж наслалтаар хамгийн өндөр үзүүлэлттэй нь Япон Улс 0.973 (82.7 жил) байна.
- ✓ **Дотоодын нийт бүтээгдэхүүнийг** Дэлхийн банкны системээр эдийн засгийн бүх орлогыг тооцох болон хэрэглээ, үйлчилгээ, экспорт зэргээр бүх зардлаар нь тооцдог байна. Дэлхийн банкны тооцоогоор нэг иргэнд 11.9 мянган ам.доллараас дээш мөнгөн дүн ногдож байвал өндөр орлоготой, 3.8 мянгаас 11.9 мянган ам.доллар бол дундаас дээгүүр орлоготой, 976-аас 3.8 мянган ам.доллар бол дунд зэргийн, 975 ам.доллараас доош орлоготой бол буурай оронд тооцогддог байна. Энэ үзүүлэлтээр АНУ тэргүүлж, хамгийн өндөр нь байгаа бөгөөд Япон удаалсан байна.



### 1.4.1. Боловсрол, шинжлэх ухаан

#### ЗОРИЛТ 2015

- Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.
- Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан технологийн хөгжлийн бодлого баримтална.

#### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2015

- ✓ 2015 онд гэр цэцэрлэгийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хувийн цэцэрлэг нээн ажиллуулах үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллана. Мөн сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, стандарт, үнэлгээ, аргагүй, технологийн шинэчлэл хийж үндэсний хэмжээнд нэвтрүүлнэ.
- ✓ 2015 онд “Авьяас”, “Ном”, “Багшийн хөгжил”, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болон Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлэхээр зорилт тавин ажиллана.
- ✓ 2016 он хүртэл нийт 549 барилга (шинээр барих барилга 389, ашиглалтын шаардлага хангахгүй хүчин чадлыг нөхөх барилга 142, 2014 оноос 2015 онд шилжих барилга 18)-ыг шинээр болон өргөтгөх шаардлагатай байна. Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2–5 насны хүүхдэд эрүүл аюулгүй, сургалтын стандарт хангасан тохилог орчинд хоол тэжээл, эрүүл мэнд, асаргаа хамгаалал, боловсролын цогц үйлчилгээ үзүүлэх бололцоо бүрдэнэ. Монгол Улсын төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад анхаарч “Монголын боловсролыг 2006–2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд тусгай хэрэгцээт боловсролын асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр 1”-ийг 2003–2008 онд хэрэгжүүлж, 2 дахь хөтөлбөрийг боловсруулан

2014–2017 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх мэргэжлийн ангиудыг багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад бий болгож, зориулалтын тоног төхөөрөмж бүхий орчинд сургалтын нэгдсэн хөтөлбөрөөр хичээллэх боломжоор хангана.

✓ 2015 онд дээд боловсролын хөгжлийг дэмжих эрх зүйн орчинг сайжруулж, судалгаа сургалт хосолсон тогтолцоог бий болгож багш, инженер бэлтгэх чиглэлийн сургуулиудын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах, суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж ажиллана. Мөн дээд боловсролын удирдлага, мэдээллийн Үндэсний системийг хөгжүүлэх болон сургалтын төрийн сангийн санхүүжилт, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийн хүрээнд дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургана.

✓ Өнөөгийн байдлаар “Цахим засаг”, “Үндэсний хиймэл дагуул”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах”, “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх”, “Өрх бүрт шуудан”, “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ” зэрэг үндэсний хэмжээний 6 томоохон хөтөлбөрийг тус салбарт хэрэгжүүлж байна.

✓ Дунд хугацаанд шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн менежментийг боловсронгуй болгохоор ажиллана. Мөн эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжлийн хандлагатай уялдуулан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн шинжлэх ухаан, технологийн салбарт инновацийн дэд бүтцийг сайжруулж, шинэ технологийн нэвтрүүлэх, нутагшуулахад төрөөс дэмжлэг үзүүлэн салбар дундын ашиглалттай төрөлжсөн лаборатори, туршилт–үйлдвэрлэлийн төв байгуулна.

## 1.4.2.Соёл урлаг, спорт, аялал жуулчлал

### ЗОРИЛТ 2015

- Соёл, урлаг, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлэх бодлого баримтална.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулна.

### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ Дунд хугацаанд биеийн тамир, спорт, соёл, урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгох, соёлын өвийг хамгаалах, сэргээх засварлах үндэсний чадавхийг сайжруулах, үнэлэмж өгөөжийг нь нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.
- ✓ Дунд хугацаанд Монгол Улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлан, салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ. Түүнчлэн бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвар өндөртэй, байгальд ээлтэй, тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэхээр төлөвлөөд байна

### 1.4.3. Хөдөлмөр эрхлэлт

#### ЗОРИЛТ 2015

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.
- Хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ Дунд хугацаанд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Ажилтай орлоготой Монгол хүн хөтөлбөр” Үндэсний хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, жил бүр 50.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллаха хүчнийг бий болгоход түлхүү анхаарч, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд үндэсний ажиллагчдыг ажиллуулж, бүтээмжтэй, тогтвортой ажлын байр бий болгоно.
- ✓ Дунд хугацаанд нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчлэх зорилгоор тэтгэврийн даатгалын тогтолцоог олон давхаргат даатгалын тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.
- ✓ Дунд хугацаанд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг дэмжиж, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- ✓ 2015 онд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, чадавхийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, стандарт, инновацийг нэвтрүүлэх, нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр ажилуудыг төлөвлөөд байна.
- ✓ Эдгээрийн үр дүнд барьцаа хөрөнгийн дутагдлаас үүдэж арилжааны банкнаас зээл авч үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөж чадахгүйд хүрээд байсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хүндрэлээс гарч дотоодын зах зээлд хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгож ашиг орлогоо нэмэгдүүлэх юм.
- ✓ Мөн мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, чадамжид суурилсан сургалт үнэлгээний тогтолцоог бүрдүүлнэ.

### 1.4.4.Эрүүл мэнд

#### ЗОРИЛТ 2015

- Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.

#### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2015

- ✓ Дунд хугацаанд эрүүл мэндийн салбарын бодлогыг сайжруулах чиглэлээр оношилгоо, эмчилгээний чанарын стандартыг шинэчлэн, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, мэс заслын тусламж, үйлчилгээнд өргөн хэргэлэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протезийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- ✓ Монгол оронд оношилж, эмчилж чадахгүй байгаа зарим өвчин эмгэгийн үед үзүүлэх оношилгоо, эмчилгээний тусламжийг гадаад орноос импортлох болон концессийн гэрээгээр гүйцэтгүүлэх зэрэг ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлого баримтлана

## 1.5. БҮС НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫНТӨЛӨВ 2015 ОНД

### ЗОРИЛТ 2015

- Хүн амын нутагшилт, суурьшилт, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 2015

- ✓ Хот, орон нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр бүс нутгийн дэд бүтцийг сайжруулах, сумын төв, хилийн боомтуудыг хөгжүүлэх, үйлдвэр, технологийн парк технологи дамжуулах төв бий болгох чиглэлээр тодорхой бодлогуудыг боловсруулан ажиллана.
- ✓ Монгол Улсын Засгийн газраас “Сум” төслийг санаачлан хэрэгжүүлж, сумдыг бүсчлэн хөдөө аж ахуйн, тэр дундаа мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, анхан шатны тордолт хийх, хадгалж тээвэрлэх, биржийн сүлжээгээр дамжуулан борлуулах, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна.
- ✓ Дунд хугацаанд байгаль орчин, ногоон хөгжлийн салбарт авч хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд агаарын чанарыг сайжруулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг гол, мөрний урсац бүрэлдэх эхийг хамруулан өргөтгөх, ойн экосистемийг хамгаалах, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул судалгаа хийх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр олон улсын стандартыг судлан нутагшуулах, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөөд байна.

## 1.6. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР 2015 ОНД

### ЗОРИЛТ

2015

- Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх бодлогыг баримтална.
- Олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.
- Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаална.
- Батлан хамгаалах, хил хамгаалалт, иргэний хамгаалалтын салбарын чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.

### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ Дунд хугацаанд Монгол улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай үргэлжлүүлэн хэрэгжүүлж, улмаар хөрш хоёр улс болон “гуравдагч хөрш” орнууд, хөгжиж буй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх, НҮБ-ын бүх гишүүн улстай дипломат харилцаа тогтоох, Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцид оролцоогоо идэвхжүүлж, олон улсын тавцанд улс орныхоо нэр хүндийг өсгөж, Монгол улсын хөгжил, дэвшлийг хангах нэн таатай гадаад орчин бүрдүүлэхээр ажиллана.
- ✓ Батлан хамгаалахын салбар нь 2015 оны үйл ажиллагаандаа энхийг дэмжих ажиллагаанд оролцох, зэвсэгт хүчний олон талт үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цэргийн дайчилгааны бодлогод шинэчлэл хийх зэрэг ажлыг төлөвлөөд байна.
- ✓ Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох хэлбэрийг өргөжүүлэх болон батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэх ажлуудыг 2015 онд төлөвлөөд байна.

## 1.7. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТӨЛӨВ 2015 ОНД

### ЗОРИЛТ

2015

- **Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.**
- **Гамшгийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.**

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2015

- ✓ Хууль зүйн салбарын хөгжлийн ойрын болон дунд хугацааны хөгжлийн хүрээнд захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, хууль зүйн нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллана.
- ✓ Шүүхийн захиргаа, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журмыг батлах, эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулах, гэрч хохирогчид туслалцаа үзүүлэх, тэднийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөөд байна.
- ✓ Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулна.





## **II ХЭСЭГ**

# **АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Дугаар 53

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний биелэлтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
53 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

А/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин, үр дүн	шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр гэрбүм төгрөг/	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 1. Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого баримтална.</b>						
1.1	Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /цаашид "ҮХЦБ" гэх/	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлэх	Дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид "ДНБ" гэх/-ий бодит өсөлт, хувь Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллар	10 хувиас доошгүй 5000 ам.доллар-оос дээш	- -	Эдийн засгийн хөгжлийн яам /цаашид"ЭЗХЯ" гэх/, холбогдох яамд
1.2	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" /цаашид "ЗҮГАХХАХТ" гэх/-ийн 5.8, 5.9, 12.1 дэх заалт	Эдийн засгийн болон мөнгөний бодлогоор дамжуулан инфляцийг нэг оронтой тоонд байлгаж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах	Жилийн эцсийн инфляцийн зорилтот түвшин	1 оронтой тоонд байлгах	-	Монголбанк
<b>Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.</b>						
2.1	ЗҮГАХХАХТ-ний 147.1 дэх заалт	Ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангуудыг нэгтгэх хууль эрх зүйн орчин бий болгох	Ажилгүйдлийн түвшин, хувь	6.6 хувь	-	Хөдөлмөрийн яам /цаашид "ХЯ" гэх/, ЭЗХЯ

2.2	ҮХЦБ-ын 4.8, "Ажилтай, орлогоой Монгол хүн" Индэсний хөтөлбөрийн 3.3 дахь заалт	Эдийн засгийн салбаруудын ажиллах хүчний төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах	Ажиллах хүчний хэгийн тооцооллыг хэрэгжүүлэх салбарын тоо	4-өөс доошгүй салбар	-	Уул уурхайн яам / цаашид "УУЯТ" гэх, Соёл, спорт, ялал жуулчлалын яам / цаашид "ССАЖЯТ" гэх, Зам тээврийн яам / цаашид "ЗТЯ" гэх, Эрүүл мэндийн яам / цаашид "ЭМЯТ" гэх/
<b>Зорилт 3. Төсвийн тогтвортой, тэнцвэрт байдалг хангах бодлого баримтлахын зэрэгцээ, санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.</b>						
3.1	ЗГҮАХХАХТ-ний 11.1, 13.1, 13.2, 14.1 дэх заалт	Төсвийн тогтвортой байдалг хангах бодлогыг хэрэгжүүлж, төсвийн зохистой харьцааг хадгалах	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэрбум төгрөг Нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээ, тэрбум төгрөг Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг	7201.1 7690.9 -489.8	-	Сангийн яам /цаашид "СЯ" гэх/, ЭЗХЯ
3.2	ЗГҮАХХАХТ-ний 25.2 дахь заалт	Гадаад улс орнуудтай байгуулсан давхар татварын гэрээг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох	Ажлын явц, хувь	100 хувь	-	СЯ
3.3	ҮХЦБ-ын 7.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 17.3, 17.4, 27.1 дэх заалт	Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох	Засгийн газрын нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	50 хувь	-	СЯ, Шадар сайдын ажлын алба
3.4	ЗГҮАХХАХТ-ний 2.1, 2.2, 2.3 дахь заалт	Зээлийн хүү бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Шинэчлэх хуулийн тоо	1	-	Монголбанк, ЭЗХЯ, СЯ
<b>Зорилт 4. Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.</b>						
4.1	ЗГҮАХХАХТ-ний 41.1 дэх заалт	Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялагийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх	Нэг цонхны бодлого хэрэгжих ажлын явц, хувь	100 хувь	-	УУЯ, ЭЗХЯ

4.2	ЗГҮАХХАХТ-ний 61.1, 61.2 дахь заалт	Дэлхийн худалдааны байгууллагын өмнө хүлээсэн үүргийн дагуу гааль, тарифын механизмыг ашиглан Үндэсний Үйлдвэрлэлээ дэмжих бодлого баримтлах	Импортын зарим бараанд нэр төрөл, бус нутаг, үйлдвэрлэгчээр нь ялгаралтай ногдуулах тарифын хувь	20 хүргэл хувь	-	СЯ, ЭЗХЯ
<b>ХОЁР-ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 5. Уламжлалт мал аж ахуйг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.</b>						
5.1	ЗГҮАХХАХТ-ний 31.1 дэх заалт	"Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг шинэчилж, салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх	Бодлогыг шинэчлэн баталж, хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /цаашид ҮХААЯ гээ/
5.2	ЗГҮАХХАХТ-ний 75.1, 75.2, 75.3, 75.4 дэх заалт	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зэвэгийн санг 50.0 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	Импортын сүүг орлуулах хэмжээ, хувь Импортын гахайн махыг орлуулах хэмжээ, хувь Өндөргийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хэмжээ, хувь	30 хувь 25 хувь 70 хувь	50.0 Улсын төсөв	ҮХААЯ, СЯ, ЭЗХЯ
5.3	ЗГҮАХХАХТ-ний 77.1, 77.4 дэх заалт	Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах	Бэлтгэх нөөцийн махны хэмжээ, мян.тонн	14.0	14.0 Улсын төсөв	ҮХААЯ, СЯ, ЭЗХЯ
5.4	ЗГҮАХХАХТ-ний 69.2, 69.3 дахь заалт	Малын гаралтай түүхий эд, ноолуур, ноос, арьс ширийг дотооддоо боловсруулах	Боловсруулах ноолуурын хувь Боловсруулах ноосны хувь Боловсруулах арьс ширний хувь	20-оос дээш хувь 50-аас дээш хувь 15 дээш хувь	120.0 Бусад эх үүсвэр	ҮХААЯ
<b>Зорилт 6. Эдийн засгийн өсөлтийг дэмжих эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлнэ.</b>						
6.1	ЗГҮАХХАХТ-ний 64.1, 65.1, 67.2, 67.3, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр /цаашид "МУЭХНС" гэх-ийн 4.1.2, 4.1.3, 4.1.19 дэх заалт	Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр бус нутаг дахь эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	80 хувь	200.0 Гадаад, дотоод эх үүсвэр	Эрчим хүчний яам /цаашид "ЭХЯ" гээ/

6.2	ЗГҮАХХАХТ-ний 56.1, 56.2, 67.11, 67.12 дахь заалт, "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр"-ийн 4.1.2, 4.2.4 дэх заалт	Цахилгаан дамжуулах сүлжээний 220 кВТ, түүнээс дээш өндөр хүчдэлийн шугамыг байгуулах	Шугамын барилга угсралтын ажлын явц, хувь	30 хувь	100.0 Концесс	ЭХЯ
6.3	ЗГҮАХХАХТ-ний 225 дахь хэсэг	Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын усан цахилгаан станцыг барьж байгуулах бэлтгэлийг хангах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, төслийн нэгж ажиллуулах	-	-	-	ЭХЯ
<b>Зорилт 7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулна.</b>						
7.1	ЗГҮАХХАХТ-ний 79.2, 79.4, 79.5, 86.1, 86.2 дахь заалт	"Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлэх	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувь	100 хувь	-	ССАЖЯ Байгаль оочин, нэгэон хөгжлийн яам /цаашид "БОНХЯТ" гэж, ЭХЯ
7.2	УХЦБ-ын 5.2, 1.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 81, 83 дахь заалт	Аялал жуулчлалыг бус нутгийн онцлог түлхүүрлэж төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	-	ССАЖЯ Барилга, хот байгуулалтын яам /цаашид БХБЯ гэж/
<b>Зорилт 8. Тээврийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжсэн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.</b>						
8.1	"УХЦБ"-ын 5.3, 1.4, "Төрөөс төмөр замын тээврийн талаар барилдлах бодлого" /цаашид ТТЗТГБВ гэж-ын 3.2.2/ ЗГҮАХХАХТ-ний 107.1 дэх заалт	1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн 225 км	100 хувь	Төсвийн бус эх үүсвэр, концесс	ЭХЯ, ЗТЯ
			Ухаа худаг-Сайншанд чиглэлийн 435 км	30 хүртэл хувь		
			Сайншанд-Баруун Урт-Хөөт чиглэлийн 430км	30 хүртэл хувь		
			Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 415 км	30 хүртэл хувь		
			Хөөт-Нөмрөг чиглэлийн 380 км	10 хүртэл хувь		
			Могойн гол – Эрдэнэт 500 км	20 хүртэл хувь		
Сайншанд-Замын-Үүд 235 км	20 хүртэл хувь					

8.2	ҮХЦБ-ын 5.3.1-4 дэх заалт	Мандаг – Зуунмод – Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтээж барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Суурь бүтээж барих ажлын явц, хувь	30 хүртэл хувь	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	ЗТЯ
8.3	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт	Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	Ашиглалтад оруулах авто замын урт	1400 км	Концесс	ЭЗХЯ
8.4	ЗГҮАХХАХТ-ний 111.1 дэх заалт	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүдийн хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын замын урт	1200 км	Концесс	ЭЗХЯ
8.5	ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь заалт	Бичигт–Баруун-Урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах	Ашиглалтад оруулах авто замын урт	267 км	Концесс	ЭЗХЯ
8.6	"Транзит Монгол" Үндэсний хөтөлбөрийн 5.2.5 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 119.3 дахь заалт.	Замын-Үүд суманд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах	Ажлын явц, хувь	90 хувь	42.5 Улсын төсөв, 8.0 АХБ-ны тусламж, 64.0 АХБ-ны зээл	ЗТЯ
8.7	ЗГҮАХХАХТ-ний 84.3 дахь заалт	Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг сурдлуулж, шинээр Сингапур, ВНСУ руу хуваарьг нислэг гүйцэтгэх	Шинээр нислэг үйлдэх чиглэлийн тоо	2 чиглэл	-	ЗТЯ
8.8	ЗГҮАХХАХТ-ний 220.3 дахь заалт, ШББДХХ-ийн 4.4.5.26 дахь заалт	Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх	Шинээр үйлдвэрлэх цахилгаан тээврийн хэрэгслийн тоо	10	2.0 Улсын төсөв	ЗТЯ, Нийслэлийн засаг дарлын Тамгын газар / цаашид НЗДТГ гэх/
<b>Зорилт 9. Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.</b>						
9.1	ЗГҮАХХАХТ-ний 50.1 дэх заалт	Дархан-Сэлэнгийн бүсэд металлургийн цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	Концесс	ЭЗХЯ, УХААЯ

9.2	ЗГҮАХХАХТ-ний 7 дахь заалт	Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн бүрхчин-эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувийр	100 хувь	0.2 Улсын төсөв	УУЯ
9.3	ҮХЦБ-ын 5.2.1.1, ЗГҮАХХАХТ-ний 38 дахь заалт	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1,50000 мянган геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийж гүйцэтгэх	Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь	36 хувь	15.0 Улсын төсөв	УУЯ
9.4	ЗГҮАХХАХТ-ний 99 дэх заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.3.2 дахь заалт	Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна.	Хувийн хөрөнгөөр	УУЯ
9.5	ҮХЦБ-ын 5.2.1.1 дэх заалт	Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Туршилтын үйлдвэр ашиглалтад орсон байна.	Зээлийн хөрөнгөөр	УУЯ
<b>Зорилт 10. Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.</b>						
10.1	ЗГҮАХХАХТ-ний 304.1 дэх заалт	Эрдэм шинжилгээний туршилтын баазыг бэхжүүлж, төрөлжсөн эрдэм шинжилгээний лаборатори, туршилт-үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинээр байгуулах	Шинээр байгуулах төрөлжсөн лабораторийн тоо	1	12.0 Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны яам /цаашид БШУЯ гэх/
10.2	ҮХЦБ-ын 5.3.4 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 38.2 дахь заалт	Өндөр нарийвчлал бүхий тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлэх	Шинээр байгуулах туршилт, үйлдвэрлэлийн төвийн тоо	1	10.0 Улсын төсөв	БШУЯ
10.3	ЗГҮАХХАХТ-ний 141.4 дэх заалт	Шилэн кабелийн сүлжээнд холбодоогүй сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбох	Шилэн кабелийн холбогдох сумын тоо	Хиймэл дагуулын төхөөрөмжийн шийдийг боловсруулж, үйлдвэрлэх ажиллаанд шилжүүлсэн байна.	50.0 Гадаад эх үүсвэр	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /цаашид МТШХХГ гэх/
				16	9.6 Улсын төсөв, бусад эх үүсвэр	МТШХХГ



ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО						
Зорилт 11. Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохиистой тогтолцоонд тулгуурлан хот, сууринг хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.						
11.1	ҮХЦБ-ын 5.3.5.1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3.5, 4.7.5.а, ЗГҮАХХАХТ-ний 106.3 дахь заалт	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл"-ийг боловсруулах	Ажлын явц, хувь	70 хувь	3.0 Улсын төсөв	БХБЯ, холбогдох яамд
11.2	ҮХЦБ-ын 5.3.5.4. ЗГҮАХХАХТ-ний 130.2 дахь заалт	Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	100 хувь	2.0 Улсын төсөв	БХБЯ, аймаг, нийслэлийн ЭДТ
11.3	ҮХЦБ-ын 5.3.5.4. ЗГҮАХХАХТ-ний 222.4, 222.5 дахь заалт	Газрын бирж байгуулах ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлэх	Бирж байгуулах ажлын явц, хувь	50 хүртэл хувь	2.5 Улсын төсөв	БХБЯ, СЯ, Хууль зүйн яам / цаашид ХЗЯ гэх/
Зорилт 12. Хүн амын орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулж, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлнэ.						
12.1	Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол	"Сумдын хөгжлийн загвар"-ын хүрээнд, үйлдвэр, технологийн парк, технологи дамжуулах төв бий болгох ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувийар	10 хувь	2.0 Гадаад эх Үүсвэр	ҮХААЯ, ЭЗХЯ
12.2	ҮХЦБ-ын 5.3.5.1, ШББДХЗ-ийн 4.4.6.2, ЗГҮАХХАХТ-ний 141.1 дэх заалт	"Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр"-ийн хүрээнд сумын төвүүдэд ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сулжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Хөтөлбөрт хамрагдах сумын тоо	20	100.0 Улсын төсөв болон бусад эх Үүсвэр	БХБЯ, ЭЗХЯ
12.3	ЗГҮАХХАХТ-ний 8 дахь заалт	Улс, бүс нутгийн онцгой ач холбогдол бүхий боомтуудын үндсэн дэд бүтэц, барилга, байгууламжийг цогцоор нь барьж байгуулах	Үндсэн дэд бүтэц, барилга байгууламж барих боомтын тоо	6	40.0 Улсын төсөв, Концесс, Гадаадын хөрөнгө оруулалт	БХБЯ, ЭЗХЯ, Боомтын нэгдсэн захиргаа

Зорилт 13. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохиистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.						
13.1	ҮХЦБ-ын Стратегийн зорилт 1-ийн 6 дугаар заалт	Агаарын бохирдлыг бууруулах урамшууллын арга хэмжээг үргэлжлүүлж, агаарын чанарыг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх	Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдаж урамшуулал авах айл өрх	71.0 мянга	5.0 Улсын төсөв	Байгаль орчин, нөлгөөн хөгжлийн яам, цаашид БОНХЯТ гэх, УУЯ, Нийслэлийн Засаг дарын Тамгын газар / цаашид ТБД гэх/
13.2	ЗГҮАХХҮАТ-ний 233.2, 233.5 дахь заалт	Ойн экосистемийг хамгаалах шинэ технологи нэвтрүүлэх, ойжуулалтын үр дүнг сайжруулах	Шинэ технологиор тэмцэл хийх талбайн хэмжээ	90 мян.га	8.0 Улсын төсөв	БОНХЯ
13.3	ЗГҮАХХҮАТ 226, Ус үндэсний хөтөлбөр 3.2, 3.3, 3.4	Гидрологийн зураглал, региональ судалгаа, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул судалгаа хийх	Ойжуулах талбайн хэмжээ	8.5 мян.га	3.2 Улсын төсөв	БОНХЯ
13.4	ЗГҮАХХҮАТ 34, 226, Ус үндэсний хөтөлбөр 3.2	Ус, агаар, хөрсний чанарыг хянах шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлж, орчны бохирдлын талаарх бодит мэдээллээр хангагдах	Шинжилгээний багачийн тоо	5	1.5 Улсын төсөв	БОНХЯ
13.5	ЗГҮАХХҮАТ 243.4	Эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч болон хяягдаг усыг цэвэрлэж дахин ашиглах "Ногоон барилга" саначилгыг нэвтрүүлэх	Төслийн тоо	1	5 Улсын төсөв	БОНХЯ

Зорилт 14. Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.						
14.1	ЗГҮАХХАХТ-ний 264.10 дахь заалт	Гамшгийн аюулгаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	2.4 Улсын төсөв	Онцгой байдлын ерөнхий газар/даашид ОБЕГ тгэх/, Засгийн газрын Хэрэг эрхлэлт газар/даашид ЗГХЭГ тгэх/, СЯ
14.2	ТХШТХ-ийн 9.3.6, ЗГҮАХХАХТ-ний 312.2, 281.2 дахь заалт	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг бий болгож, программ хангамж, техник хэрэгсэлийн хангалтыг сайжруулах	Мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын явц, хувь	100 хувьд	2.2 Улсын төсөв	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар/даашид ИМХЕГ тгэх/
<b>ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО</b>						
Зорилт 15. Хүүхэд, сурагч, багш, оюутан нэг бүрийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, боловсролын тогтолцоог шинэчилнэ.						
15.1	ЗГҮАХХАХТ-ний 194.1 дэх заалт	Боловсролын байгууллагын олон улсын багш солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрт хамрагдах багшийн тоо	40	1.0 Улсын төсөв	БШУЯ
15.2	ЗГҮАХХАХТ-ний 201.1, 201.2, 201.3	Инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж олон улсын загварыг турших	Загвар турших сургуулийн тоо	1	1.0 Улсын төсөв	БШУЯ
15.3		Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	Хөнгөлөлт үзүүлэх оюутны тоо	2300	3.4 Улсын төсөв	БШУЯ
15.4	ЗГҮАХХАХТ-ний 204.1, 204.2	Өрсөлдөх чадвартай монгол хүнийг хөгжүүлэх зорилгоор дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан сургаж арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх	Суралцуулах оюутны тоо	100	9.0 Улсын төсөв	БШУЯ

15.5.	ЗГҮАХХАХТ-ний 192.3 дахь заалт	Их, дээд сургуулиудыг түшиглэн, "Цахим сургалтын үндэсний төв" байгуулах	Шинээр байгуулах цахим сургалтын төвийн тоо	1	-	БШУЯ
15.6.	ЗГҮАХХАХТ-ний 300.1 дэх заалт	"Монгол залуу хүн" Үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх	Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	1.0 Улсын төсөв	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /цаашид, ЗАНХХЯ" гэж, ЗСХЯ
<b>Зорилт 16: Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.</b>						
16.1	ҮХЦБ-ын Стратегийн зорилт 2, ЗГҮАХХАХТ-ний 167.2 дахь заалт	Иймртын эмийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах шинэчлэлийг хийх	Олон улсын итгэмжлэл авсан байгууллагын тоо	1	0.1 Улсын төсөв	ЭМЯ
16.2	ЗГҮАХХАХТ-ний 183.2 дахь заалт	Орчин үеийн эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, Уламжлалт эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөх	Уламжлалт эмийн бүртгэлд хамрагдах хувь	25 хүртлэх хувь	0.04 Улсын төсөв	ЭМЯ
16.3	ЗГҮАХХАХТ-ний 164.1 дэх заалт	Мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх өндөр өртөг бүхий мэс заслын хэрэгсэл, протезийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	15.0 Эрүүл мэндийн даатгалын сан	ЭМЯ
16.4	ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт	Эх орондоо чанартай оношилгоо эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлж, оношилгоо эмчилгээний чанарын стандартыг шинэчлэх	Шинээр боловсруулах стандарт, удирдамжийн тоо	10	0.01 Улсын төсөв	ЭМЯ
16.5	Нийгмийн халамжийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт, 21.3 дахь хэсэг	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо	35 мянга гаруй хүн	0.4 Улсын төсөв	ЭМЯ
16.6	ЗГҮАХХАХТ-ний 185.2 дахь заалт	Хүн амын эрүүл мэндэд хотжилтын нөлөөлөгч нөлөөг судлан "Хотжилт ба эрүүл мэнд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо,	1	0.35 Улсын төсөв	ЭМЯ

Зорилт 17. Соёл, урлаг, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлэх бодлогыг баримтална.						
17.1	ЗГҮАХХАХТ-ний 1.3 дахь заалт	Биеийн тамир, спорт, соёл, урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бүрдсэн байна.	100 хувь	0.01 Улсын төсөв	ССАЖЯ
<b>Зорилт 18. Нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.</b>						
18.1	ЗГҮАХХАХТ-ний 150.2 дахь заалт	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэх	Шинээр боловсруулах хуулийн тоо	1	-	ХАХНХЯ, СЯ, ЭЗХЯ, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл / цаашид "НДҮЗ" гэх/
18.2	ЗГҮАХХАХТ-ний 153.1 дэх заалт	Зорилтот бүлэгт үзүүлэх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, төрийн оус сайгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	-	ХАХНХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ
18.3	ЗГҮАХХАХТ-ний 154.2 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээж засах, гэдний эцэг, эх, гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжин туслэх хөгжлийн төвүүдийг оух аймаг, дүүрэгт үе шаттайгаар байгуулах	Жишиг хөгжлийн төвүүдийг байгуулах ажлын явц, хувь	100 хувь	-	ХАХНХЯ, ЭМЯ, БШУГ, ХСЯ
<b>Зорилт 19. Хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах, ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>						
19.1	ҮХЦБ-ын 4.1, 4.8, "Ажилтай, орлоготой Монгол хүн" Үндэсний хөтөлбөрийн 3.9 дэх заалт	Цагийн ажлын тогтолцоо, аутсорсинг зэрэг хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрийг хөгжүүлэх	Шинээр батлах хөтөлбөр, төсөл, журмын тоо	1 багц	1.0 Улсын төсөв	ХЯ, Мэргэжлийн холбоод
19.2	ЗГҮАХХАХТ-ний 33 дахь заалт	Зэвэгийн батлан даалтын сангаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих	Батлан даалтын сангаас баталгаа гаргуулах орон нутгийн ХНДГ эрхлэгчдийн эзлэх хувь	30 хувь	10.0 ЗБДС	ХЯ, СЯ, ЭЗХЯ

19.3	"Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийн 1 дүгээр зорилт	Үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагод заалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Томоохон аж ахуйн нэгжүүдийг даган хөгжих жижиг бизнес эрхлэгчдийн тооны өсөлт, хувь	25 хувь	-	ХЯ, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн сан /цаашид "ЖДҮХС" гэж/
19.4	"Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийн 2 дугаар зорилт	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, булгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох	Борлуулалтын нөмөгдөх хэмжээ, хувь	70 хүртэл хувь	0.5 Улсын төсөв	ХЯ, СЯ, ҮХААЯ, ЭЗХЯ
19.5	ЗГҮАХХАХТ-ний 196.3 дахь заалт	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний шатлал болон тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх	Шинээр боловсруулах стандартын тоо	30 хүртэл стандарт	-	ХЯ

**ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО**

<b>Зорилт 20. Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.</b>						
20.1	ЗГҮАХХАХТ-ний 285.2 дахь заалт	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх нэгдсэн тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлэх	Тогтолцоо бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ
20.2	ЗГҮАХХАХТ-ний 309.1 дэх заалт	Шүүхийн захиргаа, зохион байгуулалт үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлэх	Стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ, ЕТГ, Шүүхийн Ерөнхий зөвлөл /цаашид "ШЕЗ" гэж/
20.3	ЗГҮАХХАХТ-ний 295.2, 295.4 дэх заалт	Эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулж, мөрдүүлэх	Стандартыг өөрчилж, мөрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ
20.4		Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлэх	Тогтолцоо бүрдүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЗЯ
20.5	ЗГҮАХХАХТ-ний 291.2, 291.3 дахь заалт	Гэрч, хохирогчид туслацаа үзүүлэх, тэднийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	14.0 Улсын төсөв	ХЗЯ

20.6	ЗГҮАХХАХТ-ний 273.1, 273.4 дэх заалт	"Архигүй Монгол хүн" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын явц, хувь	100 хувь	-	ХЭЯ, ҮХААЯ, Ерөнхийлөгчийн Тамгын газар/цаашид "ЕТГ" гэх/
<b>Зорилт 21. Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх бодлогыг баримтална.</b>						
21.1	ҮХЦБ-ын 7.5.1.8, ГБУБ-ын 2.14.3, 3.21.4, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт	Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр идэвхтэй ажиллах	АПЕК-т манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо	1-ээс дээш орон	1.5 Улсын төсөв	ГХЯ
21.2	ҮХЦБ-ын 7.5.1.9, ГБУБ-ын 2.14.3, 3.21.4, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт	Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах	Зүүн Азийн дээд түвшний уулзалтад манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо	1-ээс дээш орон	1.0 Улсын төсөв	ГХЯ
21.3	ҮХЦБ-ын 7.5.1.9, ГБУБ-ын 14.3 дахь заалт	ЗХА-ийн асуудлаарх Улаанбаатарын яриа санаачилгыг бусад улсад таниулах, дэмжлэг авах чиглэлээр ажиллах	ЗХА-ийн асуудлаарх Улаанбаатар хотын яриа хэлэлцээ санаачилгын бусад улсад танигдсан байдал, дэмжихээ илэрхийлсэн орны тоо	1-ээс дээш орон	2.0 Улсын төсөв	ГХЯ
<b>Зорилт 22. Олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.</b>						
22.1	ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГҮАХХАХТ-ний 254.1 дэх заалт	Олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр сууриа бэхжүүлэх	Байр сууриа илэрхийлэх байдал, давтамж Манай улсын санаачлан батлуулах тогтоолын тоо	2-оос доошгүй удаа 1-ээс дээш	2.1 Улсын төсөв	ГХЯ ГХЯ
22.2	ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГҮАХХАХТ-ний 254.4 дэх заалт	НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний 2022 оны сонгууль, Хүний эрхийн зөвлөлийн 2015 оны сонгуульд сонгогдох чиглэлээр ажиллах	Монгол Улс нэр дэвшиж, сонгогдох ажлын явц, хувь Сонгуульд манай улс гишүүнээр элсэхийг дэмжихээ албан ёсоор илэрхийлэх орны тоо	100 хувь 1-ээс дээш орон	5.0 Улсын төсөв	ГХЯ
22.3	ҮХЦБ-ын 7.5.1.7, ГБУБ-ын 2.14.4, ЗГҮАХХАХТ-ний 254.1 дэх заалт	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлэх	ЕАБХАБ-ын үйл ажиллагаанд дахь манай улсын оролцоо	2-оос багатай удаа оролцсон байна.	1.1 Улсын төсөв	ГХЯ

22.4	ҮХЦБ-ын 7.5.1.1, ГБҮБ-ын 1.4.2.14.5, ЗГҮАХХАХТ-ний 253.12 дахь заалт	Монгол Улстай дипломат харилцаагүй, нҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх	Дипломат харилцаа тогтоох орны тоо	2-оос доошгүй орон	0.2 Улсын төсөв	ГХЯ
<b>Зорилт 23.Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаална.</b>						
23.1	ҮХЦБ-ын 7.5.3.1, ГБУБ-ын 6.27.5, ЗГҮАХХАХТ-ний 258.1 дэх заалт	Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалж, "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Сангийн үйл ажиллагаа өргөжсөн байна.	-	1.0 Улсын төсөв	ГХЯ СЯ
23.2	ГБУБ-ын 6.27.3, ЗГҮАХХАХТ-ний 258.2 дахь заалт	Гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх хүрээнд бусад улстай визгүй харилцан зорчих, визийн нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр ажиллах	Хөнгөвчлөх нөхцөлтэйгээр зорчих хэлэлцээр хийсэн орны тоо	2-оос доошгүй орон	0.8 Улсын төсөв	ГХЯ
23.3	ГБУБ-ын 2.14.5, 7.29.4, ЗГҮАХХАХТ-ний 256.1 дэх заалт	Монгол Улсын ардчилал, хүний эрх, зах зээлийн эдийн засгийн замнал, туршлагыг хөгжиж байгаа бусад улстай хуваалцах зорилгоор Олон улсын хамтын ажиллагааны сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Хөгжиж байгаа бусад улсад үзүүлсэн техникийн тусалцааны төслийн тоо	1-ээс дээш төсөл	3.5 Улсын төсөв	ГХЯ
<b>Зорилт 24.Батлан хамгаалах, хил хамгаалалт, иргэний хамгаалалтын салбарын чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.</b>						
24.1	ЗГҮАХХАХТ-ний 247.4 дэх заалт	Хил дамнансан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааг үе шатай хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	30.3 Улсын төсөв	ХЗЯ Хил хамгаалах ерөнхий газар /цаашид, ХХЕГ гэх/
24.2	ЗГҮАХХАХТ-ний 247.2 дахь заалт	Хилийн асуудлаар хөрш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт	30 хувь	0.45 Улсын төсөв	ХЗЯ ХХЕГ
24.3	ЗГҮАХХАХТ-ний 244.7 дахь заалт	Цэргийн дайчилгааны бодлогод шинэчлэл хийж, дайчилгааны нөөц бүрэлдэхүүнийг сургах тогтолцоог боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	143.3 Улсын төсөв	Батлан хамгаалахын ям /цаашид "БХЯ" гэх/, Зэвсэгт хүчний жанжин штаб /цаашид "ЭХЖШ" гэх



24.4	ЗГҮАХХАХТ-ний 248.1 дэх заалт	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хэлбэрийг өргөжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	20.7 Улсын төсөв	БХЯ ЗХЖШ
24.5	ЗГҮАХХАХТ-ний 249.4 дэх заалт	Батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэн боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	55.5 Улсын төсөв	БХЯ ЗХЖШ
24.6	ЗГҮАХХАХТ-ний 251.5 дахь заалт	Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100 хувь	24.0 Улсын төсөв	БХЯ ЗХЖШ

---000---

## Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2011	2012	2013*	2014**	2015**
<b>Бодлогын үзүүлэлтүүд</b>					
ДНБ-ий бодит өсөлт /хувь/	17.5	12.4	11.7	11.2	10.2
Хөдөө аж ахуй	-0.5	21.6	13.5	8.7	9.6
Үйлдвэр	9.1	9.9	20.1	18.5	19.1
Үйлчилгээ	16.8	16.3	10.0	10.1	7.7
Уул уурхайн салбарын бодит өсөлт	7.3	8.0	20.7	25.0	21.9
Уул уурхайн бус салбарын бодит өсөлт	19.7	13.2	10.1	8.5	7.5
Нэг хүнд ногдох ДНБ /мян. төгрөгөөр/	3,979.4	4,934.6	6,053.9	7,190.2	8,152.2
Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллар/	3,144.5	3,630.4	3,972.4	4,254.5	5,199.1
Хэрэглээний үнийн өөрчлөлт, оны эцэст	10.2	14	12.5	9	7
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	4159.6	4,864.8	5,881.0	6,884.0	7,201.1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4792	5,925.80	6,178.0	7,293.8	7,690.9
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-632.4	-1061	-297.0	-409.8	-489.8
<b>Төсөв, ДНБ-д эзлэх хувь</b>					
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	37.5	34.9	33.5	32.5	29.4
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	43.2	42.5	35.2	34.4	31.4
Нийт тэнцэл	-5.7	-7.6	(1.7)	(1.9)	(2.0)
Төлбөрийн тэнцэл /сая ам доллар/	27.8	1,705.0	- 1,883.3	134.2	511.2
Гадаад худалдааны тэнцэл /сая ам.доллар/	(1,746.5)	(2,353.8)	(2,082.0)	(645.4)	127.6
ДНБ-д эзлэх хувь	-19.9	-23.1	-18.1	-5.1	0.8
Экспорт	4780	4385	4273	5611	6885
өсөлт, хувь	64.4	-8.3	-2.6	31.3	22.7
Импорт	6526.9	6,738.40	6,354.70	6,256.30	6,757.50
өсөлт, хувь	104.0	3.2	-5.7	-1.5	8.0
<b>Суурь үзүүлэлтүүд</b>					
ДНБ оны үнээр, /тэрбум.төг/	11,087.7	14,012.9	17,550.2	21,213.4	24,491.2
Хүн амын дундаж тоо, мянган хүнээр	2786.3	2,839.70	2,899.54	2,964.04	3,029.79
Ажилгүйдлийн түвшин /хувь/	7.7	8.2	8.0	7.1	6.6
ДНБ сая ам.доллараар	8761.5	10209.8	11520.4	12543.1	15126.4



**© Энэхүү товхимолыг үнэгүй тарааж байгаа бөгөөд ашиг олох зорилгоор олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.**

Боловсруулсан: Ж.Батсайхан

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Уранчимэг

Д.Цэцэгмаа

ЭЗБХ-ны ажлын алба

Утас: 267451

Факс: 327016